



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2024/129-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2024 он

Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Аудитын менежер: М.Нарантуяа

Утас: 99029193 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор/аудитор: Б.Бүзмаа

Утас: 91160110 Цахим хаяг: buzmaa@mindug.mn

Миндүг аудит ХХК-ийн захирал: С.Энхтөр

Утас: 95957791 Цахим хаяг: director@mindug.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	9
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	11

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

**СҮХБААТАР АЙМГИЙН
ЭРДЭНЭЦАГААН СУМЫН
ХҮҮХДИЙН 1 ДҮГЭЭР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Г.АЛТАНТУЯА ТАНАА**

2024.02.25 № 141
танай _____ - ны№ _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэцагаан сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэцагаан сумын Хүүхдийн 1 дүгээр цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дээд шатны төсвийн захирагчаас 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээнд улсын төсвөөс 741,507.3 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн орлого 14,420.0 мянган төгрөг нийт 755,927.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, орон нутгийн төсвөөс 34,983.0 мянган төгрөг санхүүжилт хийгджээ.

Аудитын гол асуудал

Тухайн жилд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 77,300.9 мянган төгрөг болж, 55,932 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх оны үлдэгдлийг зарцуулаагүй, цалингийн төсөв дээр санхүүжилт нэмж хуваарилсантай холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно. 2023 онд үйл ажиллагааны орлого 5.4 хувиар буюу 42,349.9 мянган төгрөгөөр өссөн байх ба урсгал зардал 34 хувиар буюу 186,395,4 мянган төгрөгөөр өссөн. Гүйцэтгэлээр 90.5 хувийн биелэлттэй байна. 2023 онд байгууллагын багш нарын гүйцэтгэлийн урамшуулалд 13,753,4 мянган төгрөгийн урсгал зардал гаргасан байна.

Эдгээр тайланд материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй тул аудит хийсэн санхүүгийн тайланд залруулга хийх шаардлагагүй гэж үзлээ.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Г.ДАВАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	72,598,445.54	139,979,026.24
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	21,368,895.54	77,300,906.24
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	21,368,895.54	77,300,906.24
3121	Төгрөг	21,368,895.54	77,300,906.24
31211	Төрийн сангийн харилцах	21,368,895.54	77,300,906.24
33	АВЛАГА	121,800.00	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	121,800.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	51,107,750.00	62,678,120.00
354	Хангамжийн материал	51,107,750.00	62,678,120.00
35410	Бичиг хэргийн материал	100,500.00	-
35420	Аж ахуйн материал	50,369,250.00	62,678,120.00
35440	Түлш, шатах тослох материал	638,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	149,948,344.60	163,447,784.02
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	149,948,344.60	163,447,784.02
392	Биет хөрөнгө	143,154,344.60	156,953,784.02
39201	Барилга, байгууламж, орон сууц	126,369,687.47	124,973,447.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	(17,553,792.91)	(18,856,536.75)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	37,596,000.00	57,893,400.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(16,198,108.44)	(25,419,516.56)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,357,113.64	24,107,113.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	(7,905,088.36)	(9,756,656.94)
39214	Бусад үндсэн хөрөнгө	880,000.00	3,880,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(586,666.80)	(1,062,666.84)
39217	Ном	1,195,200.00	1,195,200.00
393	Биет бус хөрөнгө	6,794,000.00	6,494,000.00
39301	Програм хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(200,000.00)	(500,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,494,000.00	5,494,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	222,546,790.14	303,426,810.26
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,500,000.00	1,500,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,500,000.00	1,500,000.00
413	Өглөг	1,500,000.00	1,500,000.00
41340	Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	1,500,000.00	1,500,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	221,046,790.14	301,926,810.26
51	Засгийн газрын хувь оролцоо	221,046,790.14	301,926,810.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	57,051,022.23	57,051,022.23
51101	Өмч: - төрийн	57,051,022.23	57,051,022.23
512	Хуримтлагдсан үр дүн	102,716,974.22	183,596,994.34
51210	Өмнөх үеийн үр дүн	(122,208,585.63)	102,716,974.22
51220	Тайлант үеийн үр дүн	224,925,559.85	80,880,020.12
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	61,278,793.69	61,278,793.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	222,546,790.14	303,426,810.26

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	780,023,442.68	822,373,347.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	196,105,491.54	31,463,047.82
120	Нийтлэг татварын бус орлого	196,105,491.54	31,463,047.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	196,105,491.54	31,463,047.82
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,144,813.76	3,404,777.82
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	166,960,677.78	28,058,270.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	583,917,951.14	790,910,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	514,484,900.00	741,507,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	514,484,900.00	741,507,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	14,420,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	14,420,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	69,433,051.14	34,983,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	69,433,051.14	34,983,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	555,097,882.83	741,493,327.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	555,097,882.83	741,493,327.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	555,086,252.22	741,489,164.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	379,473,724.85	502,649,311.76
210101	Үндсэн цалин	291,892,821.29	367,375,394.58
210102	Нэмэгдэл	73,364,978.53	121,520,463.34
210104	Урамшуулал	14,215,925.03	13,753,453.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,444,629.51	63,576,325.36
210201	Тэтгэврийн даатгал	33,190,170.37	43,325,163.98
210202	Тэтгэмжийн даатгал	3,815,316.47	5,092,166.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,045,032.41	4,073,572.16
210204	Ажилгүйдлийн даатгал	763,282.87	1,007,756.37
210205	Эрүүл мэндийн даатгал	7,630,827.39	10,077,666.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,244,599.68	30,617,656.77
210301	Гэрэл, цахилгаан	3,142,903.31	5,624,144.27
210302	Түлш, халаалт	20,601,696.37	21,993,412.50
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	3,000,100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,935,581.82	-
210408	Бараа материал акталсны зардал	1,935,581.82	-
2105	Нормативт зардал	72,238,345.00	91,994,330.00
210502	Хоол, хүнс	72,238,345.00	91,994,330.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	4,999,180.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,999,180.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,101,200.00	1,329,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,101,200.00	1,329,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,648,171.36	46,322,760.58
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,290,860.00	27,788,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,780,000.00	3,986,300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,577,311.36	14,547,960.58
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,630.61	4,163.23
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,630.61	4,163.23
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,630.61	4,163.23
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	224,925,559.85	80,880,020.12
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	224,925,559.85	80,880,020.12

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	613,062,764.90	794,315,077.82
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,144,813.76	3,404,777.82
120	Нийтлэг татварын бус орлого	29,144,813.76	3,404,777.82
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,144,813.76	3,404,777.82
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	29,144,813.76	3,404,777.82
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	583,917,951.14	790,910,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	514,484,900.00	741,507,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	514,484,900.00	741,507,300.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	14,420,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	14,420,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	69,433,051.14	34,983,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	69,433,051.14	34,983,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	79,793,869.36	731,233,067.12
21	УРСГАЛ ЗАРДАЛ	579,793,869.36	731,233,067.12
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	79,782,238.75	731,228,903.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	379,763,724.85	502,649,311.76
210101	Үндсэн цалин	292,182,821.29	367,375,394.58
210102	Нэмэгдэл	73,364,978.53	121,520,463.34
210104	Урамшуулал	4,215,925.03	13,753,453.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	48,566,429.51	63,454,525.36
210201	Тэтгэврийн даатгал	33,311,970.37	43,203,363.98
210202	Тэтгэмжийн даатгал	3,815,316.47	5,092,166.14
210203	ҮОМШО-ний даатгал	3,045,032.41	4,073,572.16
210204	Ажилгүйдлийн даатгал	763,282.87	1,007,756.37
210205	Эрүүл мэндийн даатгал	7,630,827.39	10,077,666.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	30,471,369.39	29,979,656.77
210301	Гэрэл, цахилгаан	3,142,903.31	5,624,144.27
210302	Түлш, халаалт	24,828,466.08	21,355,412.50
210303	Цэвэр, бохир ус	2,500,000.00	3,000,100.00
2105	Нормативт зардал	71,283,955.00	91,994,330.00
210502	Хоол, хүнс	71,283,955.00	91,994,330.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,000,000.00	4,999,180.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,999,180.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,101,200.00	1,329,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,101,200.00	1,329,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	43,595,560.00	36,822,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,815,560.00	32,836,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,780,000.00	3,986,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,630.61	4,163.23
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	11,630.61	4,163.23
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11,630.61	4,163.23
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	33,268,895.54	63,082,010.70
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	11,900,000.00	7,150,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	11,900,000.00	7,150,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	11,900,000.00	7,150,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	11,900,000.00	7,150,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	11,900,000.00	7,150,000.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	21,368,895.54	55,932,010.70
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	21,368,895.54
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	21,368,895.54	77,300,906.24

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	57,051,022.23	61,278,793.69	22,870,742.15	141,200,558.07
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-145,079,327.78	-145,079,327.78
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	57,051,022.23	61,278,793.69	-122,208,585.63	-3,878,769.71
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	224,925,559.85	224,925,559.85
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	57,051,022.23	61,278,793.69	102,716,974.22	221,046,790.14
D01	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	57,051,022.23	61,278,793.69	102,716,974.22	221,046,790.14
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	57,051,022.23	61,278,793.69	102,716,974.22	221,046,790.14
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	80,880,020.12	80,880,020.12
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	57,051,022.23	61,278,793.69	183,596,994.34	301,926,810.26

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	815,672,700.00	738,378,903.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	815,672,700.00	738,378,903.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	815,672,700.00	738,378,903.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	561,054,600.00	502,649,311.76
210101	Үндсэн цалин	386,351,600.00	367,375,394.58
210102	Нэмэгдэл	162,111,700.00	121,520,463.34
210104	Урамшуулал	12,591,300.00	13,753,453.84
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,626,300.00	63,454,525.36
210201	Тэтгэврийн даатгал	48,000,500.00	43,203,363.98
210202	Тэтгэмжийн даатгал	5,656,600.00	5,092,166.14
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,525,000.00	4,073,572.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,131,300.00	1,007,756.37
210205	Эрүүл мэндийн даатгал	11,312,900.00	10,077,666.71
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,983,000.00	29,979,656.77
210301	Гэрэл, цахилгаан	4,500,000.00	5,624,144.27
210302	Түлш, халаалт	21,483,000.00	21,355,412.50
210303	Цэвэр, бохир ус	4,000,000.00	3,000,100.00
2105	Нормативт зардал	103,694,500.00	91,994,330.00
210502	Хоол, хүнс	103,694,500.00	91,994,330.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,400,000.00	7,399,180.00
210602	Тавилга	2,400,000.00	2,400,000.00
210604	Урсгал засвар	5,000,000.00	4,999,180.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,329,600.00	1,329,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,329,600.00	1,329,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,584,700.00	41,572,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	37,596,000.00	37,586,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,988,700.00	3,986,300.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	776,490,300.00	776,490,300.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	776,490,300.00	776,490,300.00
122005	Орон нутгийн төсвөөс	776,490,300.00	776,490,300.00

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	21,368,895.54
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	77,305,069.47
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	300.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	1.00
610001	Төсвийн байгууллага	-	1.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	-	32.00
620001	Удирдах ажилтан	-	3.00
620002	Гүйцэтгэх ажилтан	-	19.00
620003	Үйлчлэх ажилтан	-	10.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	-	235.00
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА	-	235.00
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	-	235.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	-	32.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	-	20.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	-	12.00

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 7 зөрчил¹ илэрснээс, 1 төлбөрийн акт тогтоож, 3 албан шаардлага хүргүүлж, 3 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул Өөрчлөлтгүй дүгнэлт өгөх саналтай байна.

3.1 Төлбөрийн акт

Нийгмийн даатгалын тайланд нэг ажилтанд 2023 оны 06 дугаар сарын тайланд олгосон 1,301.0 мянган цалинг тусгаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйл, 21 дүгээр зүйлтэй нийцэхгүй байна.

3.2 Албан шаардлага

Тухайн байгууллагын нэг ажилтны цалинг нийгмийн даатгалын тайланд 299,337.68 төгрөгөөр дутуу тайлагнасан, Нийгмийн даатгалын тайланд датгуулагчийн код буруугаас датгуулагчийн шимтгэлийг 63,250,0 төгрөгөөр илүү суутгасан, 2023 оны 07 дугаар сард олгосон хэсэгчилсэн ээлжийн амралтын мөнгө 360,909 төгрөгийг Нийгмийн даатгалын тайланд тусгаагүй зэрэг зөрчлүүд нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 19 дүгээр зүйл, 21 дүгээр зүйлтэй нийцэхгүй байна

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.3 Зөвлөмж

Илрүүлэлт:

Хоол, хүнс болон бусад материалын худалдан авалтад тендер зарлаагүй, шууд гэрээ байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4."хуульд өөрөөр заагаагүй бол бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэх этгээдийг чөлөөт өрсөлдөөн, нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар сонгох", Монгол Улсын Засгийн газрын 2021 оны "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 124 дүгээр тогтоолын хавсралтын 2 "Харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 70.0 сая, шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар 20.0 сая гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд зааснаар төсөв батлагдсанаас хойш 10 өдрийн дотор захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төсвийн ерөнхийлөн захирагч цахим системээр илгээнэ гэснийг мөрдөж ажиллах

Шилэн данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудаст 2023 онд нийт 1 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэн стандартыг тогтоох журам", "-тай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах. Шилэн дансны www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлэх үүрэгтэй албан тушаалтан мэдээллийг тогтоосон хугацаанд нь тогтмол мэдээлэх, хуулийн хэрэгжилтийг бүрэн биелүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
НДШ тайланд Ц.Болорчимэг ажилтанд 2023 оны 06 сарын тайланд олгосон цалинг тусгаагүй орхигдуулсан байна	1	1,301.0	1	1,301.0								
Ажилтан О.Алтантуулын 7 сарын олговол зохих цалин төгрөг байсныг НД-ын тайланд төгрөгөөр дутуу тайлагнасан	1	299,3			1	299,3						
Нийгмийн даатгалын шимтгэлийн даатгуулагчийн код буруугаас даатгуулагчийн шимтгэл илүү суутгасан	1	63.3			1	63.3						
2023 оны 07 дугаар сард олгосон хэсэгчилсэн ээлжийн амралтыг НДШ тайланд тусгаагүй	1	360.9			1	360.9						
Үдийн цай хөтөлбөр, худалдан авалтын гэрээ байхгүй.	1	-	-	-	-	-	1	-				
Шилэн дансны 1 мэдээлэл хоцроосон	1						1					
Дүн	7	3,420.8	1	1,301,0	3	723.5	2	-				